

ИТАЛИ ЗОХИОЛЧДЫН ЗАРИМ БҮТЭЭЛИЙН МОНГОЛ ОРЧУУЛГЫН ТУХАЙД

Г. Бат-Учрал¹¹

Товч утга: *Итали зохиолчдын бүтээлээс монгол хэлнээ орчуулагдсан нь ховор хэдий ч монгол хэлнээ орчуулагдсан тэрхүү цөөн хэдэн бүтээл нь бараг бүгд дэлхийн шилдэгт багтдаг байна. Энэ удаа монгол хэлнээ орчуулсан “Тэнгэрлэг туульс” хэмээх нэгэн алдарт зохиолын тухай товчхон авч үзэх болно.*

Түлхүүр үг: *Италийн уран зохиол, орчуулга, тэнгэрлэг туульс*

Итали улс нь соёл, уламжлалын арвин их түүхтэй, суурин соёл иргэншлийн өлгий болсон орон юм. Тиймдээ ч италийн соёл, урлаг түүхийн тодорхой цаг үед цэцэглэн хөгжиж ирснийг хэн бүхэн мэдэх билээ. Европын хамгийн анхны их сургууль 1088 онд Италид байгуулагдсан нь өнөөгийн Болонягийн Их Сургууль юм. Энэ нь тус улсын эрдэмтэн, судлаачдын чадвар чансааг нотлох нэгэн баримт болохын зэрэгцээ, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрт үеэс эхэлсэн болохыг харуулж байна. Энэ ч үүднээс Италийн зохиолч, яруу найрагчдын зохиол, бүтээл дэлхийн тавцанд төвөггүй гарсан байна.

Орчин цагийн италийн уран зохиолчдоос Умберто Эко, Франко Баттиатозэрэг олонд танигдсан бүтээлч олон хэдий ч дэлхийд танигдсан уран бүтээлчид мөн цөөнгүй байна. Тэдгээр зохиолчдын шилдэг бүтээлүүдээс монгол хэлнээ орчуулагдан гарсан бүтээл мэр сэр байгаа ч орчин цагийн италийн уран зохиолын бүтээл хараахан орчуулагдаагүй байна. Өөрсдийн зохиол бүтээлээрээ дэлхийд танигдсан итали зохиолчдоос дурьдвал, Данте Алигьери (1265-1321), Франческо Петрарка (1304-1374), Жованни Бокаччо (1313-1375) нар юм. Эдгээр зохиолчдын бүтээл, туурвил нь тухайн цаг үеийн шилдэг нь байсан төдийгүй, дэлхийн уран зохиолын шилдэг бүтээлүүдэд тооцогддог. Дээрхи бүтээлээс дурьдвал, Дивинья Коммедя (Данте Алигьери), Декамерон (Жованни Бокаччо), Канцониере (Франческо Петрарка) зэрэг орно.

Итали зохиолчдын туурвисан бүтээлээс монгол хэлнээ орчуулагдсан нь харьцангуй цөөн хэдий ч, Данте Алигьери “Дивинья Коммедя” 1-р дэвтэр 1981, 2-р дэвтэр 1987, 3-р дэвтэр 1990 онд, Жованни Бокаччо “Декамерон” зэрэг италийн уран зохиолын шилдэг, шалгарсан бүтээл орчуулагдсан нь монгол эрдэмтэн, судлаач, орчуулагч нарт нэн таатай зүйл билээ.

Мөн италийн алдарт аялагч Марко Пологийн аялалын тэмдэглэл “Орчлонгийн элдэв сонин” нэрээр 1987, Раффаелло Жованьоли “Спартак” 1964 онд тус тус орчуулагдан хэвлэгдсэн байна. Дээрхи бүтээл нь бүгд орос хэлээр

¹¹ МУИС, ШУС, ХУС-ын Европ судлалын тэнхимийн багш

дамжин монгол хэлнээ орчуулагдсан нь дараахи хэдэн шалтгаантай байж болох талтай. Нэгдүгээрт, Монгол-Оросын харилцаа олон жилийн түүхтэй ба манай улс орос хэлтэй, орос хэлний мэргэжилтэн бэлтгэж ирсэн нь дэлхийн шилдэг ном, зохиолыг төрөлх хэлээрээ унших боломж олгосон. Хоёрдугаарт, тухайн үед итали хэлтэй мэргэжилтэн ховор байсан нь итали ном зохиолыг эх хэлээс нь шууд монголчилон буулгах боломж хомс байсантай холбоотой юм. Монгол улс анх Зөвлөлт Холбоот Улсад итали хэлтэй боловсон хүчнээ бэлтгэдэг байсан бөгөөд 2004 оноос МУИС-д итали хэлний үндэсний боловсон хүчин бэлтгэж эхэлжээ.¹² Үндэсний боловсон хүчин бэлтгэж эхэлсэн 12 жилийн хугацаанд монгол, итали хүнд зориулсан ярианы дэвтэр 4, толь бичиг 3, хэлзүйн дүрмийн ном 2, үлгэрийн ном 10, зурагт толь бичиг 2, бусад гарын авлага 4 гарсан хэдий ч итали хэлнээс монгол хэлнээ шууд орчуулан буулгасан дорвитой бүтээл “Монголчуудын түүх (HistoriaMongalorum) 2006”-аас өөр хараахан гараагүй байна.

Данте Алигьери “Тэнгэрлэг туульс” бүтээлийн орчуулгын тухай

“Дивинья Коммедя” бүтээлийг Данте Алигери 1304-1321 оны хооронд Лигүрря мужийн Лүнижана гэх газар цөллөгт байх үедээ бичсэн ба түүний хамгийн оргил бүтээл юм. Уг бүтээл нь тухайн үеийн нийгмийн амьдрал, улс төр, шашин зэрэг бүхий л салбарыг хамарсан гэдгээрээ онцлогтой бөгөөд мөн Тоскана мужийн флоренц аялгуу италийн утга зохиолын хэл болон хөгжихөд үнэтэй хувь нэмэр оруулсан юм. Тус бүтээл нь 3 хэсэгтэй ба нийт 14233 мөр шүлгээс бүрдэнэ. Эхний хэсэг болох “Там” нь 34, “Ариутгалын орчлон” нь 33, “Диваажин” нь 33 дууллаас бүрдэх бөгөөд “Там” нь хамгийн эхний ба оршил хэсэг учир нэг дууллаар илүү байна. “Дивинья Коммедя” хэмээх энэхүү бүтээлийг ЗСБНХУ-ын төрийн шагналт орчуулагч М.Лозинскийн орос орчуулгыг барин уран зохиол судлаач, орчуулагч Ц.Хасбаатар анх удаа монголчилсон байдаг бөгөөд тус бүтээлээ 1980-1990 оны хооронд туурвисан байна. Тэрээр “Дивинья Коммедя” гэх бүтээлийг “Тэнгэрлэг туульс” хэмээн монголчилж, “Там”, “Ариутгалын орчлон”, “Диваажин” гэх гурван хэсгийг монгол хэлнээ чадамгай буулгахдаа цаад утга санааг алдагдуулаагүй болох ньуг бүтээлийн итали эхтэй харьцуулан үзэхэд ажиглагдаж байна. Данте Алигьери “там” гэх хэсгээ найруулгазүйн түвшиний хувьд гол төлөв доод найруулга буюу ардын итали хэлээр бичсэн бол “диваажин” гэх сүүлчийн хэсгийг дээд найруулгаар бичсэн байна. Уг бүтээлээ тэрээр нийгмийн дээд, доод давхаргын талаар тэнцүү авч үзсэн тул дундаж найруулгатай болсон гэж үзсэн байна.

Итали хэлнээс монгол хэлнээ шууд орчуулагдсан бүтээл нэн ховор байгаа хэдий ч итали зохиолчдын зарим бүтээлийг орос хэлээр дамжуулан монголчилсон нь манай орчуулагчдын авьяас, чадварыг харуулаад зогсохгүй

¹²Буяннэмэх Г., Монгол улсын боловсролын салбарын хэлний бодлого, ЭШХ-ын эмхэтгэл, УБ., 2007, н. 32.

монгол уншигчдад дэлхийн шилдэг бүтээлийг орос хэлээр дамжуулаад ч болов эх хэлээрээ унших боломж олгож байна.

Дүгнэлт

Итали зохиолчдын эх хэлээрээ бичсэн бүтээлийг монгол хэлнээ шууд орчуулах нь тухайн ард түмний соёл, уламжлалын талаарх аливаа ухагдахууныг үнэн зөв ойлгоход тустай ч бусад хэлээр дамжуулан орчуулах нь уг ойлголтыг алдагдуулна гэсэн үг биш бөгөөд энэ нь орчуулагчийн авьяас, чадвараас шалтгаална. Гиймээс монгол хэлнээ орчуулагдсан итали зохиолчдын бүтээлийг итали хэл дээрхи эхтэй нь тулган утга, санаа өөрчлөгдсөн тохиолдолд залруулах, мөн итали хэлнээс монгол хэлнээ шууд орчуулан өмнөх хувилбартай харьцуулан нягтлах, цаашлаад хоёр хэлнээ орчуулах асуудлыг эхлүүлэх хэрэгтэй гэж үзэж байна.

Ном зүй

Монгол хэлээр:

Буяннэмэх Г., *Монгол улсын боловсролын салбарын хэлний бодлого, ЭШХ-ын эмхэтгэл*, УБ., 2007, н. 32.

Нямаа Л., *Монголчуудын түүх*, УБ., 2006.

Хасбаатар Ц., *Данте Алигьери, Тэнгэрлэг туульс (Там)*, УБ., 1981.

Хасбаатар Ц., *Данте Алигьери, Тэнгэрлэг туульс (Ариусгалын орчлон)*, УБ., 1987.

Хасбаатар Ц., *Данте Алигьери, Тэнгэрлэг туульс (Диваажин)*, УБ., 1990.

Итали хэлээр:

Alberto Beniscelli, Vittorio Coletti, *Strumento per lo studio della letteratura italiana*, Firenze, 1992.

Dante Alighieri, *Divina Commedia*, Milano, 1966.

Riccardo Brusagli, *Letteratura e storia, Dalle origini all'eta` comunale*, Firenze, 2005.